

Contents

- 2 日本語版
- 4 Bản tiếng Việt [ベトナム語版]
- 6 中文版 [中国語版]
- 8 Bersyon sa Pilipino [フィリピン語版]
- 10 Edisi Bahasa Indonesia [インドネシア語版]
- 12 ฉบับภาษาไทย [タイ語版]
- 14 ភាសាខ្មែរ [カンボジア語版]
- 16 မြန်မာဘာသာ မူ [ミャンマー語版]
- 18 Монгол хэл дээрх хувилбар [モンゴル語版]
- 20 English Version [英語版]

こくごのもり

小学低学年の児童を対象に国語の楽しさを知ってもらおうと、イラストを多用してつくった問題で「毎日小学生新聞」に長期連載。

©毎日小学生新聞 複製、転用はできません

The illustration depicts a swimming pool scene where children are engaged in various activities. The activities are labeled with Japanese words: 'あびる' (take a bath), 'うく' (float), '水しぶき' (water splashes), 'およく' (eat well), 'うきわ' (floatation device), 'つめたい' (cold), 'シャワー' (shower), 'あそぶ' (play), 'ひらおよぎ' (float on one's back), 'もぐる' (swim), 'くるしい' (tiring), 'ふかい' (deep), 'きもち' (feeling), 'ようす' (appearance), 'うごき' (movement), and 'もの・こと' (things/objects). Children are shown playing with a ball, swimming, and using a floatation device. A girl is taking a shower, and a boy is drying himself with a towel. The scene is framed by a large window or board.

こくごのもり
指導・元世田谷区立
小学校教諭
高橋 伸子
イラスト・奈良 恵

**ことば
言葉のなかま**
いろいろな言葉（ことば）を声（こゑ）に出（だ）して読（よ）み、
言葉（ことば）のなかまをまとめ（まと）めましょ（ま）う。

答えはP22にあります。

Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2022 оны 7-р сар, зуны дугаар

Усны осол, уулын ослоос болгоомжлоорой! - Зуны амралтаа аюулгүй сайхан өнгөрөөхийн тулд-

Японы нутаг нутгийн үзэсгэлэнт далай, гол мөрөн, уулуудаар жил бүр олон хүмүүс амралтаараа зочилж очдог. Харин сайн төлөвлөлгүйгээр явснаас улбаалан осол гарвал, амь настай ч холбогдож болзошгүй учраас дараах зүйлсэд сайн анхаараарай.

✓ Усны ослоос сэргийлэхийн тулд

- Нойр дутуу ч юм уу бие тааруу үедээ сэлэхээс татгалзаарай. Мөн, согтууруулах ундаа уусны дараа сэлэх нь тун аюултай тул, хэрхэвч болохгүй.
- Далайд усны гүний түвшин зэргээсээ хамааран усны температурын өөрчлөлт ихтэй газар, усны урсгал нь ширүүн газар г.м газрууд байдаг. Ийм аюултай газруудад “Аюултай.”, “Сэлэхийг хориглоно” гэх зэргээр таниулах тэмдэг тавьсан байх нь олонтаа байдаг тул, далайн эрэг, далайд сэлэх газарт тавигдсан тэмдэг зэргийг сайтар нягталж, сэлэхийг хориглосон бүсэд хэрхэвч орохгүй байх.
- Гол мөрөнд усны урсгал нь хурдан газар, огцом гүнзгий болдог газар олон байдаг тул, анхааралтай сэлээрэй. Мөн, гол мөрний хажууд байх үедээ цаг агаарын өөрчлөлт, гол мөрний төлөв байдал зэрэгт анхаарал, сэрэмжтэй байх. Дараах өөрчлөлт ажиглагдвал, голын ус огцом нэмэгдэхийн тэмдэг ба даруй байгаа газраасаа холдоорой.
 - Голын эх (ус урсаж ирж буй зүг)-ийн тэнгэрт бараан үүл гарсан бол
 - Бороо орж эхэлсэн бол
 - Цахилгаан цахих нь сонсогдсон бол
 - Модны навч, модны мөчир г.м хог урсаж ирсэн бол
- Их хэмжээний бороо орсноос даланд ус их хэмжээгээр орсон тохиолдолд болон бусад шалтгаанаар ч далангаас урсгалын адаг руу гадагшлуулах усны хэмжээ нэмэгдэх тохиолдол байдаг. Дуут дохио, сэрэмжлүүлэг зэргээр энэ талаар мэдэгдсэн бол, нэн даруй гол мөрнөөс холдоорой.
- Орохыг хориглосон газарт орж, загас барих нь тун аюултай. Мөн, цаг агаар таагүй байгаа өдөр загас барьж хэрхэвч болохгүй. Загас барих, завинд суух зэрэг тохиолдолд аврах хантаазыг зөв өмсөөрэй.

✓ Уулын ослоос сэргийлэхийн тулд

- Биеийн тамир тэнхээ болон биеийн байдал, мөн ууланд авирах туршлага болон цаг агаарын нөхцөл байдалд тохирсон уулыг сонгоорой. Ууланд авирах маршрут, цагийн хуваарь, бэлтгэл хэрэгсэл болон хоол хүнс зэргийг бодолцож, ууланд авирах аюулгүй төлөвлөгөө гаргаарай. Замд гарахаасаа өмнө сайтар судлах нь чухал юм.
- Уулын цаг агаар гэнэт өөрчлөгдсөнөөс улбаалж ууланд төөрөх тохиолдол их гарч байна. Ууланд авирахаар товлосон өдрөөсөө хэд хоногийн өмнөөс эхлэн очих газрынхаа цаг агаарт анхаарч, хэрвээ цаг агаар тааруу бол ууланд авирахаа болиорой.
- Ууланд төөрсөн тохиолдолд тухайн нутгийн цагдаагийн газар зэрэгтэй холбоо барьж, тусламж хүсэх боломжтой байхуйцаар гар утас г.м харилцааны хэрэгслийг биедээ авч яваарай. Илүү батарей авч явах нь зүйтэй болов уу.

★Шинэ төрлийн коронавирус зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээ (Амны хаалт зүүх, Дараах 3 зүйлээс зайлсхийх: 1. Цэвэр агаарын солилцоо муутай орчин, 2. Олон хүн бөөгнөрсөн газар, 3. Ойрхон зайнаас хүнтэй харилцан ярилцах нөхцөл байдал, Гараа ойр ойрхон угаах, Гар хуруугаа ариутгах г.м)-г авч, цагаа хөгжилтэй өнгөрөөгөөрэй!


※Энэ хэсгийг Японы Засгийн газрын Олон нийттэй харилцах онлайн албанаас гаргасан нийтлэлд үндэслэн, JITCO боловсруулсан болно.

 <https://www.gov-online.go.jp/useful/article/201407/3.html#section3>

JITCO нь, Японд амьдарч буй гадаадын иргэд ая тухтай амьдрахад шаардагдах дүрэм, Японы зан заншил зэргийн талаарх мэдээлэл, гамшгийн үед анхаарах зүйлс зэргийн талаар тусгасан гарын авлага “Япон улсад амьдрах гарын авлага”-ыг худалдаалж байна.

Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбож, Мьянмар, Монгол, Англи, Лаос, Синхала, Непал хэл гэсэн 12 хэл дээр хэвлэн гаргасан.

JITCO-гийн сурах бичгийн онлайн дэлгүүрээс худалдан авах боломжтой.

 <https://onlineshop.jitco.or.jp/shopdetail/00000000147/ct39/>



Шинэ төрлийн коронавирус - Халуурсан, ханиалгасан тохиолдолд-

Та бүхэн шинэ төрлийн коронавируст халдвараас сэргийлэхийн тулд өдөр тутамд төрөл бүрийн арга хэмжээ авч байгаа болов уу. Хэчнээн анхаарч болгоомжиллоо ч халуурах, ханиалгах тохиолдол байдаг. Биеийн байдал тань ердийн үеэс өөр байгаа бол, ажил хийх, гадагшаа гарах, хоолонд орох зэргээр бусадтай биечлэн харьцахаас зайлсхийж, юуны өмнө ажлын газар, Хянан зохицуулагч байгууллагын удирдагч зэрэгтэйгээ холбоо бариарай. Оршин сууж буй бүсийнхээ Зөвлөгөө өгөх цонхыг ашиглаарай. Эмнэлэгт үзүүлээд, халдварласан байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд, шинэ төрлийн коронавируст халдварын шинжилгээ өгнө.

Шинжилгээнд PCR шинжилгээ гэх мэт байдаг ба шинжилгээний дүн эерэг гарсан тохиолдолд, илэрч буй шинж тэмдгээсээ хамааран, эмнэлэгт хэвтэн, эсвэл гэртээ биеэ амраана. Халуурах г.м шинж тэмдэг илэрснээс хойш 7-10 хоног орчмын дараа шинэ төрлийн коронавирусээр халдварласан өвчтөнөөс бусдад халдварлах нь багасдаг гэдэг нь тогтоогдсон. Тиймээс энэхүү хугацаа өнгөрсөн эсэх болон төрөл бүрийн шинжилгээний дүнг ерөнхийлөн дүгнэж, хэвийн амьдралдаа эргэн орох болно. Халдварыг тараахгүйн тулд ч гэсэн энэхүү хугацааг заавал баримтлаарай.



(Дэлгэрэнгүй: Бүсийн Зөвлөгөө өгөх цонхны жагсаалт)

<https://www.moj.go.jp/isa/content/930004512.pdf>

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Японы зуныг хэрхэн өнгөрөөх вэ —



Япончууд салхин хонхыг халуун зунд сэрүүвтэр дуу сонсож баясах хэрэгсэл болгон хэрэглэдэг.

Японы зун халуунаас гадна чийгтэй болохоор амны хаалт зүүгээд гадагшаа гарахад ч хэцүү шүү. Байгаль дунд модны сүүдэрт сэрүүцэх, гэр дотроо “сэрүүхэн” санагдах арга болгож, салхин хонхны дуу сонсох гэх мэтээр арга сэдэнгээ зуныг давж гараарай.



テーマは「言葉の分類」です。
人や物の名前や事柄を表す「名詞」、動きや働きを表す「動詞」、他の性質やありさまを表す形容詞、他にもいろいろあります。
その分類の名を「もの・こと」、「うごき」、「きもち・ようす」としてまとめると、形の上でもグループごとの性質が分かります。
問題には入れなかった感動詞、「ワー」、「キヤーツ」のあの声も聞こえてきそうですね。

Chủ đề của chúng ta hôm nay là "từ loại". Để chỉ người và vật chúng ta có "danh từ", để chỉ hành động, chúng ta có "động từ", để chỉ tính chất, chúng ta có tính từ v.v. và còn nhiều loại từ khác. Khi chúng ta tập chung những từ loại đó vào từng nhóm như "đồ-vật", "chuyển động", "tình cảm, trạng thái" thì chỉ cần nhìn vào hình ảnh thứ 2, chúng ta cũng có thể đoán được tính chất của từng nhóm. Ngoài ra, dù trong câu hỏi hôm nay không đề cập đến nhưng nhìn tranh ta cũng có thể cảm nhận được những từ cảm thán tượng thanh, ví dụ như "Wa-" (Ồa!) hoặc "Kya" (Đã quá!) v.v.

主题是“词的分类”。有代表人和事物的名称和事物的“名词”，代表动作和功能的“动词”，表示其他属性和方式的形容词等等。如果将分类的名称概括为“物/事”、“动作”、“感觉/情形”，就可以从形体上了解各组的特点。我们似乎还能彷彿听到没有列入问题中的情感动词，“Wa”和“Cha”的，那种声音。

Ang tema ay "klasipikasyon ng mga salita". May mga "pangngalan" na kumakatawan sa mga pangalan at bagay ng mga tao at bagay, "mga pandiwa" na kumakatawan sa mga galaw at tungkulin, mga pang-uri na kumakatawan sa iba pang mga katangian at paraan, at iba pa. Kung pagsasamahin o ibubuod mo ang mga pangalan ng mga klasipikasyon bilang "mono/ koto", "ugoki", at "kimochi / yousu", mauunawaan mo ang mga katangian ng bawat grupo sa mga tuntunin ng hugis. Maririnig mo ang mga emosyonal na pandiwa, "Waa-" at "Kyaa-", na hindi nakalagay sa tanong.

Tema kali ini adalah "klasifikasi kata". Ada "kata benda" yang menunjukkan orang, nama benda dan hal, "kata kerja" yang menunjukkan gerakan, kata sifat yang menunjukkan sifat dan keadaan, dan sebagainya. Jika nama klasifikasi diringkas sebagai "benda/hal", "gerakan", dan "perasaan/keadaan", karakteristik masing-masing kelompok dalam bentuknya dapat dipahami. Kita seperti dapat mendengar kata seru, "Wa!" dan "Kya!", yang tidak dimasukkan ke dalam soal.

หัวข้อคือ "การจำแนกประเภทคำ"
"คำนาม" ระบุชื่อเรียกหรือเรื่องของคนหรือสิ่งของ "คำกริยา" แสดงการเคลื่อนไหวหรือการกระทำ คำคุณศัพท์แสดงคุณลักษณะหรือสภาพนอกเหนือจากนั้น และก็ยังมีความอื่น ๆ อีกมากมาย
หากสรุปการจำแนกคำดังกล่าวโดยตั้งชื่อกลุ่ม "สิ่งของ-เรื่อง" "การเคลื่อนไหว" "ความรู้สึก-สภาพการณ์" เราก็จะรู้ได้ถึงคุณลักษณะในแง่รูปลักษณะของของแต่ละกลุ่ม แม้ว่าในคำถามจะไม่มีคำดูทาน แต่คุณอาจจะรู้สึกเหมือนได้ยินเสียงดูทาน "ว่า" "กรี๊ด" ก็ได้

ប្រធានបទអំពី «ការចាត់ថ្នាក់នៃពាក្យ» ។ មាន «នាម» ពិពណ៌នាអំពីឈ្មោះរបស់មនុស្សនិងវត្ថុ «កិរិយាសព្ទ» ពិពណ៌នាអំពីចលនាឬដំណើរការ «គុណនាម» ពិពណ៌នាអំពីសភាពឬលក្ខណៈសម្បត្តិ និងថ្នាក់ពាក្យផ្សេងៗទៀត។ ប្រសិនបើអ្នកសង្ខេបឈ្មោះនៃចំណាត់ថ្នាក់ជា «របស់ / រឿង» «ចលនា» និង «អារម្មណ៍ / ស្ថានភាព» អ្នកក៏អាចយល់ពីលក្ខណៈសម្បត្តិនៃក្រុមនីមួយៗតាមរយៈលក្ខណៈរបស់ពាក្យ។ អ្នកអាចឮពាក្យខុសសព្ទដែលមិនមានក្នុងសំណួរនេះដូចជា «អូ» «អូយយ៉ា»។

ခေါင်းစဉ်က "စကားလုံးအမျိုးအစား" ဖြစ်ပါတယ်။ လူ့ အရာဝတ္ထုတွေရဲ့နာမည်တွေ၊ အကြောင်းအရာတွေကိုပြတဲ့ 「名詞」(နာမ်)၊ လှုပ်ရှားမှု၊ လုပ်ဆောင်မှုကိုပြတဲ့ 「動詞」(ကြိယာ)၊ တခြားအသွင်အပြင်၊ အနေအထားကိုပြတဲ့ 「形容詞」(နာမဝိသေသန)၊ ဒါတွေအပြင် အမျိုးမျိုးရှိပါသေးတယ်။ အဲဒီအမျိုးအစားတွေကို "အရာဝတ္ထု/အကြောင်းအရာ"၊ "လှုပ်ရှားမှု"၊ "ခံစားချက်/ပုံစံ" ဆိုပြီး ခွဲကြည့်ရင် ပုံသဏ္ဍာန်အနေအထားအရလည်း အုပ်စုအလိုက်သဘောသဘာဝကို နားလည်နိုင်ပါတယ်။ မေးခွန်းထဲမှာထည့်မထားတဲ့ 感動詞 (အာမေဇိတ်) 「ワー」(ဟေး)၊ 「キヤーツ」(အောင်မယ်လေး) စတဲ့ အသံတွေတောင် ကြားလာရတော့မလို့ပါ။

Сэдэв: "言葉の分類 / Kotoba no bunrui / Угийн ангилал". Хүн, юмсын нэр болон юмс үзэгдлийг илэрхийлдэг "名詞 / mei-shi / нэр үг", хөдөлгөөн, үйл хөдлөлийг илэрхийлдэг "動詞 / doo-shi / үйл үг", бусад шинж чанар болон төлөв байдлыг илэрхийлдэг "形容詞 / keiyoo-shi / тэмдэг нэр" болон эдгээрээс гадна төрөл бүрийн үгнүүд бий. Энэ ангиллын нэрийг "もの / mono / юм, こと / koto / юмс үзэгдэл", "うごき / ugoki / хөдөлгөөн", "きもち / kimochi / сэтгэл", "ようす / yoosu / төлөв байдал" гэж нэгтгэвэл, хэлбэрийн хувьд ч групп тус бүрийн онцлогийг нь мэдэх боломжтой. Асуултанд оруулаагүй "感動詞 / kandoo-shi / сэтгэл хөдлөл илэрхийлэх үг" болох "ワー / vaa / vaa", "キヤーツ / kyaa / киаа" гэсэн дуу ч сонсогдох шиг санагдана.

The theme here is the "classification of words." There are a variety of classifications. For example, there are "nouns," which express the name of a person, object, or event, "verbs," which express a motion or action, and "adjectives," which express a property or state of something, among others. By grouping these classifications into "things and events," "movements," and "feelings and appearances," we can gain a clear grasp of the characteristics of each group also from the "shape" of the words. Interjections were not included in this exercise, but doesn't it almost feel as if you could hear the "wows" and squeals of delight?

技能実習生・研修生向日本語情報誌 発行 公益財団法人 国際人材協力機構 (JITCO)
技能実習生の友 総務部広報室
2022年7月 夏季号 〒108-0023
2022年7月1日発行 東京都港区芝浦2-11-5
五十嵐ビルディング
電話 03-4306-1166 (ダイヤルイン)
JITCO ホームページ https://www.jitco.or.jp/